

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2017-03 САР)


Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2017 оны 3 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ болон хуучин, нийт 4,906 орон сууцны үнийг хамруулсан болно.

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

2017 оны 3 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 0.2%-иар өссөн бол өнгөрсөн оны мөн үеэс 3.3%-иар буурчээ.


Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ орон сууцны үнэ өссөн нь орон сууцны үнийн индекс бага зэрэг өсөхөд нөлөөлжээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



Орон сууцны үнийн индексийг 2013 оны 1 дүгээр сараас тооцож эхэлсэн бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн ба орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/




Жишээ: БЗД-ийн “Американ дэнж” хотхонд 2016 оны 3 дугаар сард орон сууцны 1 м² дундаж үнэ 2,029,000 төгрөг байсан бол 2017 оны 3 дугаар сарын байдлаар 1,921,000 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.3%-иар буурсан байна.

1. Шинэ орон сууцны үнэ¹

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2017 оны 3 дугаар сарын байдлаар 2,045,000 төгрөг болж өмнөх сараас 0.29 хувиар буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 0.21 хувиар өссөн байна.


ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2017.3/	
Орон сууцны дундаж үнэ	2,045,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	+0.21%
Сарын өсөлтийн хувь	-0.29%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /дүүргээр, сая.төгрөг/




2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр²

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ³ нь 2017 оны 3 дугаар сарын байдлаар 72,974,000 төгрөг болж өмнөх сараас 0.40 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 9.60 хувиар тус тус буурсан байна.


ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2017.3/	
Орон сууцны дундаж үнэ	72,974,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-9.60%
Сарын өсөлтийн хувь	-0.40%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сар,төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /дүүргээр, сая.төгрөг/



Эх үүсвэр: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

¹ Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.

² Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

³ 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)